



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A/43

Алтрага

Сумын Засаг даргын дэргэдэх  
дотоод аудитын нэгж байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хууль-ийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, бүх шатны шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Чимэдцэрэн (Засаг даргын орлогч)

Гишүүд: М.Баттулга (Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Дэлгэрмаа (Санхүүгийн албаны дарга)

Д.Бямбадалай (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ж.Даваажав (Мал эмнэлэгийн улсын байцаагч)

Ц.Мөнхболд (Ерөнхий боловсролын сургуулийн багш)

Г.Болормаа (4 дүгээр багийн эмч)

Ж.Шинэжаргал (Хүүхдийн цэцэрлэгийн багш)

Нарийн бичгийн дарга: З.Наранцэцэг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2. Дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Л.Чимэдцэрэн)-д даалгасугай.

3. Байгууллага болон төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд заавар журмын дагуу дотоод хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажиллахыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 23 ны өдрийн А/128 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010095